

ХРИСТИТГЭЛТ ХҮН ГЭЖ ХЭН БЭ? (Who is a Christian)

Бурхан бол ганц гэдэгт итгэхэд л хангалттай юу?

Үгүй

Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг. ЧӨТГӨРҮҮД Ч МӨН
ҮҮНД ИТГЭДЭГ БӨГӨӨД ЧИЧИРДЭГ ЮМ. (Иаков 2:19)

Есүс Бурханы Хүү гэдэгт итгэхэд л хангалттай юу?

Үгүй

БУЗАР СҮНСНҮҮД ЕСҮСИЙГ ХАРАХ БОЛГОНДОО өмнө нь унаж,
—ТА БОЛ БУРХАНЫ ХҮҮ МӨН ГЭЖ ХАШХИРАЛДАЖ БАЙВ. (Марк 3:11)

Шашинлаг байхад л хангалттай юу?

НАМАЙГ “ЭЗЭН МИНЬ, ЭЗЭН МИНЬ” ГЭСЭН БОЛГОН ТЭНГЭРИЙН
ХААНЧЛАЛД ОРОХГҮЙ. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг
биелүүлдэг хүн орно. Тэр өдөр Надад олон хүн “Эзэн минь, Эзэн минь, бид
Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон
гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би
тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас
зайл” гэж хэлнэ. (Матай 7:21-23)

Тэгвэл Христитгэлт гэж хэн бэ?

...ХЭРЭВ ХЭН НЭГЭНД ХРИСТИЙН СҮНС БАЙХГҮЙ БОЛ ТЭР ТҮҮНИЙХ
БИШ. (Ром 8:9б)

Христгэй байх нь чухал уу?

Ийм үед Еврей, Еврей бус, хөвч хөндүүлсэн, хөндүүлээгүй, харь омгийн, эсвэл
зэрлэг Скиф омгийн, боол, чөлөөт иргэн эсэх нь Ертөнцийн Эзэнд ялгаагүй. Та
нарт ч энэ чухал биш. Бүгдэд хамаатай, БҮХНЭЭС ИЛҮҮ ЧУХАЛ ЮМ БОЛ
ЗӨВХӨН ЕСҮС ХРИСТ МӨН. (Колоссай 3:11 МБН)

Христгэй байх нь яагад чухал вэ?

Гэрчлэл нь энэ байна. БУРХАН БИДЭНД МӨНХ АМИЙГ ӨГСӨН БӨГӨӨД
ЭНЭХҮҮ АМЬ НЬ ТҮҮНИЙ ХҮҮГИЙН ДОТОР БАЙНА. (1 Иохан 5:11)

Та Христийг хэрхэн хүлээн авах болмжтой вэ?

Есүс

– Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв ХЭН НЭГЭН НЬ МИНИЙ ДУУГ СОНСООД ХААЛГАА НЭЭВЭЛ, БИ ТҮҮНИЙ ДОТОР ОРЖ, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно. (Илчлэлт 3:20)

Та гэм нүглээ хэрхэх ёстой вэ?

Есүс тэдэнд хандаж

—"Христ зовлон эдэлж, гурав дахь өдрөө үхэгсдээс амилах болно.

Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр НҮГЛИЙН УУЧЛАЛЫН ГЭМШИЛ тунхаглагдах ёстой" гэж бичигдсэн юм. (Лук 24:46,47)

Хэрэв БИД НҮГЛЭЭ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРВӨЛ Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. (1 Иохан 1:9)

Та амьдралаа хэрхэх ёстой вэ?

Хилэнцтэн нь ӨӨРИЙН ЗАМАА, шударга бус хүн нь ӨӨРИЙН БОДОЛ САНААНУУДАА ОРХИОД, ЭЗЭН УРУУ ЭРГЭХ БОЛТУГАЙ. Түүнийг Тэр өрөвдөнө. Бидний Бурхан уруу эргэгтүн. Учир нь Тэр өгөөмрөөр уучилна. (Исаиа 55:7)

Та Есүсийг амьдралдаа авснаараа юу болох вэ?

Харин ӨӨРИЙГ НЬ ХҮЛЭЭН АВСАН БОЛГОНД, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст БУРХАНЫ ХҮҮХЭД БОЛОХ ЭРХИЙГ ТЭР ӨГӨВ. (Иохан 1:12)

Та Түүнд итгэн Христийг амьдралдаа хүлээн авсаны дараа хэзээ мөнх амьтай болдог вэ?

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. ИТГЭДЭГ ХҮН МӨНХ АМЬТАЙ. (Иохан 6:47)

Та Христэд итгэн амьдралдаа хүлээн авснаар ямар эрх эдэлдэг вэ?

Хэрэв хэн нэгний нэр амийн номд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдсан байна. (Илчлэлт 20:15)

ЯМАР Ч БУЗАР ЮМ болон жигшүүрт зүйл үйлддэг болон худал ярьдаг хэн ч хэзээ ч ТИЙШЭЭ ОРОХГҮЙ. ХАРИН ЗӨВХӨН ХУРГАНЫ АМИЙН НОМД НЭРС НЬ БИЧИГДСЭН ХҮМҮҮС Л ОРОХ АЖГУУ. (Илчлэлт 21:27)

Та Христийг өөрийн амьдралдаа хүлээн авснаар таны нэр амийн номд бичигдээсээ гэж хүсэж байна уу? Тэгвэл та дараах залбирлыг хэлээрээ:

Эзэн Есүс ээ, би гэмтээ гэдгээ хүлээн зөвшөөрж байна. Би Таны өмнө бүх гэм нүглээ дэлгэж байна. Мөн бүх гэм нүглийнхээ төлөө Таны өмнө гэмшиж байна. Би тэдгээрийг мартан, тэдгээрээс эргэхийг сонгож байна. Би Таныг өөрийн амьдралдаа Аврагч хэмээн хүлээн авч байна. Энэ цаг мөчөөс эхлэн Та миний амьдралын Эзэн мөн Багш байх болтугай. Есүсийн нэр дээр, Амээн.